



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒5 оны ᠒᠕ сарын 11 өдөр

Дугаар ᠒/᠓

Улаанбаатар хот

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 116 дугаар цэцэрлэгийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Багш ажилчид, эцэг эхчүүдээс хандивласан нийт 9,786,200.00 (есөн сая долоон зуун наян зургаан мянга хоёр зуу) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн 116 дугаар цэцэрлэг (Н.Лхагва)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 116 дугаар цэцэрлэг (Н.Лхагва)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 11 өдрийн 011... дугаар тушаалын хавсралт

Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 116 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалта нд орсон	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ		Нэр	Эх үүсвэр
						Нэгжийн үнэ	Нийт үнэ		
1.Машин тоног төхөөрөмж									
1	Өнгөт зурагт 42 инч BSB	2024	сайн	ш	4	639,800.00	2,559,200.00	Хандив	
2	Принтер /epson/	2024	сайн	ш	2	760,000.00	1,520,000.00		
3	Хүнсний складны хөргүүр /arina/	2024	сайн	ш	1	1,200,000.00	1,200,000.00		
4	1-р хоолны тогоо /100л /	2024	сайн	ш	1	3,400,000.00	3,400,000.00		
машин тоног төхөөрөмжийн дүн							8,679,200.00		
2.Тавилга, эд хогшил									
1	Ажилчдын хувцасны шкаф	2024	сайн	ш	3	369,000.00	1,107,000.00	Хандив	
тавилга эд хогшлын дүн							1,107,000.00		
Нийт дүн							9,786,200.00		